



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/654

Мөрөн сум

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад,  
хашаа, худгийн тооллогыг зохион байгуулах  
комисс байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1"в", "и", 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Тооллогын ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, малыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил, дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг тооллогын Комиссын дарга (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.


3.Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явцад хяналт тавьж, тооллогын явцын мэдээг тухай бүр танилцуулж ажиллахыг Статистикийн хэлтэс (Б.Базардамбуу)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны  
12 дугаар сарын 04-ны өдрийн 4/654  
дугаар захирамжийн хавсралт



2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА, ХУДГИЙН  
ТООЛЛОГЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Ц.Гансүх

(Аймгийн Засаг даргын орлогч)

Комиссын орлогч дарга:

Б.Базардамбуу

(Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Оюунтуяа

(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга)

С.Ганболд

(Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Я.Эрхэмбаяр

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Өнөрбат

(Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Л.Ариунаа

(Мал эмнэлгийн газрын дарга)

Д.Мөнхжаргал

(Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Нарийн бичгийн дарга:

Т.Алтанцэцэг

(Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

---oOo---